*Л.Алтансүх - Хууль сахиулахын удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн профессорын багийн профессор, хуранйаа*

# ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД МӨРДӨГДӨЖ БУЙ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮДИЙГ СИСТЕМЧЛЭХ ТУХАЙ

***Хураангуй.*** *Манай орны эрх зүйн шинэтгэлийн хүрээнд үндэсний эрх зүйн шинэ тогтолцоо бүрэлдэн тогтож байгаа энэ үед хүчин төгөлдөр үйлчилж байгаа актуудын нийт актуудын дотор нэг, эсвэл хэд хэдэн зүйл заалт, хэсэг хүчин төгөлдөр хэвээр байгаа нэг харилцааг зохицуулж байгаа олон тооны актууд өөрөөр хэлбэл: "актын хэсгүүд " хэвээр хадгалагдсаар байна. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа актуудыг консолидацлах, нэг төрлийн харилцааг зохицуулж байгаа актуудыг нэгтгэн нэг том актад нэгтгэх асуудал нь хууль тогтоомжийг журамлах ажиллагааны үндсэн чиглэлийн нэг болж байна.*

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулахад нэгдүгээрт хууль тогтоомжоор хүлээлгэсэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан нийтээр дагаж мөрдөх журмыг боловсронгуй болгох, хоёрдугаарт байгууллагын дотоод журмыг хөгжүүлэн боловсронгуй болгох шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д: "Агентлагийн хэмжээнд агентлагын даргын хууль тогтоомжид нийцүүлэн баталсан хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөнө”[1] гэж заажээ. Энэ зохицуулалт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны журмыг баталж мөрдүүлэх эрх зүйн үндэс болохын зэрэгцээ аливаа байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох нэгэн хүчин зүйл гэдгийг судлаачид, Монгол Улсын тэргүүлэх зэргийн эрдэмтэд илэрхийлдэг.

Цагдаагийн байгууллага нь энэхүү үйл ажиллагааны стандарт журмаа 2011 онд боловсруулан гаргасан байна.

Цагдаагийн байгууллага үйл ажиллагааны дүрэм журмаа боловсруулан системчлэхдээ Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудад судалгаа хийж, цагдаагийн байгууллагад 90 гаруй хуулиар хүлээлгэсэн 160 гаруй хэм хэмжээг хэрэгжүүлэх болон урьд цагдаагийн

[1] http://www.legalinfo.mn/

алба хаагчдын үйл ажиллагааг зохицуулж байсан дүрэм, журам, зааврын давхардал, хийдлийг арилгах, бичиг баримтыг нэгдсэн стандартад оруулах замаар 9 бүлэг 256 журмыг системчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдөж байна. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам 2017 оныг "Иргэдэд ойр эрх зүйн үйлчилгээний жил" болгох зорилт дэвшүүлсэн бөгөөд энэхүү зорилттой уялдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага 2017 онд "Эрх зүйн орчинг боловсронгуй болгох” зорилт дэвшүүлсэн байна.

Монгол Улсад одоогоор 590 гаруй хууль батлагдан хүчин төгөлдөр үйлчилж байгаагаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь үйл ажиллагаандаа 13 орчим хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 3 зарлиг, Засгийн газрын 13 тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 4. Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар баталсан 31, ШШГЕГ-ын даргын тушаалаар баталсан 74 орчим заавар, журмыг мөрдөн ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.22-д: “Хууль зүйн судалгааны чанарыг шинэ түвшинд гаргаж. хууль тогтоомжийн боловсруулалт, хэрэгжилтийг судалгаанд суурилан хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.”, 5.2.11-д: “Хууль, эрх зүйн актуудын давхардал, зөрчилтэй заалтуудыг илрүүлэх, арилгах, шинэ хуулийн төсөл боловсруулахад эрх зүйн цахим мэдээллийн нэгдсэн санг ашиглах замаар хууль, эрх зүйн баримт бичгийн агуулга, уялдаа холбоог дээшлүүлнэ.”, 5.4.1-д: “Хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож, иргэдэд чирэгдэлгүй, ялгаваргүй, тэгш, шударгаар үйлчлэх эрх зүйн орчинг цогцоор нь бүрдүүлнэ.”[1] гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамнаас “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ын төслийг боловсруулан, УИХ-аар батлуулахаар өргөн барьсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь эрх зүйн актыг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой ажлуудыг санаачлан хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал, Монгол Улсын Хууль зүйн сайдын 2016 оны А/121 дүгээр тушаалаар "ШШГБ-ын хөгжлийн стратеги хөтөлбөр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталж, энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх стратегийн зорилгодоо “Эрх зүйн орчныг боловсронгуй болгох,...” гэж тодорхойлоод, эдгээр зорилтуудыг 2016-2026 он хүртэл 3 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөн, төсөв, арга хэмжээний зардлыг

[1] http://www.zasag.mn/news/khotolbor

төлөвлөсөн байна. Ингэж хэрэгжүүлснээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулиар хүлээсэн үүргээ чанарын өндөр түвшинд гүйцэтгэх, "шийдвэр гүйцэтгэх ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй болж, иргэдэд түргэн шуурхай үйлчилж, шүүхийн шийдвэр нэг мөр хэрэгжинэ.[1]" гэж заажээ.

Аливаа байгууллага төрийн өмнө хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэхдээ алсын хараа, эрхэм зорилго, хөгжлийн стратеги хөтөлбөр зөв тодорхойлон түүнд хүрэх дунд болон урт хугацааны хөтөлбөр хэрэгжүүлснээр хүссэн үр дүндээ хүрч тухайн байгууллагын үндсэн үүрэг биелэгдэнэ. Хөтөлбөрөө хоосон уриа шинжтэй байлгахгүйн тулд жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган, бодлогын, эдийн засгын гэх мэт дэмжлэгийг үзүүлэх зайлшгүй шаардлагатай байдаг.

Стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ ШШГЕГ нь улсын төсөв болон зарим стратегийн зорилтыг өөрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар дотоод эх үүсвэр бүрдүүлж хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 1-р зорилтод "ШШГЕГ-т эрх зүйн актуудын нэгдсэн сан бий болгох[2]" арга хэмжээг авч хэрэгжүүлснээр байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй эрх зүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгох, тус байгууллагын үйл ажиллагаатай холбогдон гарсан эрх зүйн актуудын өөрчлөлт, шинэчлэлт, ном, сурах бичиг болгон бусад шаардлагатай мэдээллээр алба хаагчдыг цаг тухайд нь хангахаар тусгасан.

Төрийн албан хаагчийн хариуцлагыг сайжруулах хэрэгтэй байна, төрийн албаны үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгох хэрэгтэй байна гэх шүүмжлэл, яриа өгүүлэл бүрийн цаана төрийн албан хаагчийн албан тушаалын хариуцлага бүдгэрч, ёс зүй доройтож, мэргэжлийн алдаа, ёс зүйн зөрчил дутагдал ихсэж, гэмт хэрэг. зөрчил ч үйлдэгдэж байгаа хэрэг.[3]

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2016 оны жилийн эцсийн байдлаар гаргасан тайланд "Хорих анги, алба, салбар нэгжийн алба хаагчдын гаргасан зөрчил, оногдуулсан сахилгын шийтгэлийн судалгаа"[4]-гаар ажилдаа хариуцлагагүй хандаж, сахилгын зөрчил гаргасан тайланд

[1] ШШГБ-ын хөгжлийн стратеги хөтөлбөр. УБ., 2016.
[2] Стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө
[3] *Ж.Ганбаатар.* Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын менежментэд тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам. онол практикийн хурлын илтгэл. 2015.
[4] ШШГЕГ. Мониторинг, статистик мэдээлэл" УБ., 2017.29-32-р тал

хамрагдсан алба хаагчдын 8.5 хувьд нь сахилгын шийтгэл оногдуулсан байна. Сахилгын шийтгэл оногдуулсан алба хаагчдын гаргасан зөрчлийг төрөлжүүлэн үзвэл:

Ажлын байрны тодорхойлолт болон хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлээгүй -51 %;

Цэргийн сахилгын дүрэм зөрчсөн -2 %;

Ёс зүйн зөрчил гаргасан -1 %;

Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил тасалсан -20 %;

Хоногийн жижүүрлэлтийн үүрэг гүйцэтгж байх хугацаандаа унтсан -3 %;

Согтууруулах ундаа хэрэглэсэн -19 %;

Ялтан, хоригдогчтой хувийн харьцаа тогтоосон -3,3 %;

Ялтан. хоригдогчтой зүй бус харьцсан -0,3 %;

Захиргааны зөрчил гаргасан -0,3 % байна.

Зөрчлийн 51 хувийг “Ажлын байрны тодорхойлолт болон хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлээгүй’" гэсэн зөрчил ээлж байна. Үүнээс дүгнэлт хийхэд алба хаагчид ажил үүргээ гүйцэтгэхдээ өөр өөрийн үзэмжээр асуудалд хандах, эрх зүйн мэдлэг дутах, хууль тогтоомжоор олгосон эрх, үүргээ мэдэхгүй, хэрэгжүүлэхгүй байх, хэтрүүлэн хэрэглэж байна гэж ойлгож байна.

*Эрх зүйн бичиг баримтыг системчлэх /кодлох/, эрх зүйн мэдээллийн сан бүрдүүлэх гэж юуг хэлэх вэ?* Хууль зүйн техникийн асуудалд хууль цаазын олон эрдэмтэд анхаарлаа хандуулж, түүний ойлголт, зарчим, хэрэгцээ шаардлагын талаар анхаарлаа хандуулж хандуулж байна. Аливаа акт, баримт бичгийг гаргахдаа санаандаа орсныг зүгээр нэг бичээд гаргачихгүй, тэрэнд нь бас тодорхой дүрэм, заавар, стандарт байдаг. Үүнийг мэргэжлийн хэллэгээр техник гэдэг.

Харин хууль зүйн техник нь эрх зүйн хэм хэмжээний болон эрх зүйн хэм хэмжээг хэрэглэсэн актуудыг бэлтгэх, хэлбэршүүлэх, эмхлэн цэгцлэх болон түүнийг хэрэглэхэд ашиглагдаж байгаа журам, арга, хэрэгслүүдийн цогц мөн гэж тодорхойлж болно.[1] Хууль зүйн техникийн зорилго нь хууль зүйн үйл ажиллагааг оновчтой болгох, хууль зүйн актуудыг тодорхой стандартаар ижилтгэх, товч, тодорхой, энгийн болгох явдал юм.

Эрх зүйн техникийн зорилтоос улбаалаад хууль зүйн техникийг гурав ангилан үзэж болох юм.

[1] *Ч.Нямсүрэн.* Эрх зүйн ерөнхий онол. - УБ., 2010. 227 дугээр тал.

1. Эрх зүйг бүтээх техник /эрх зүйн хэм хэмжээний актыг бэлтгэх, албан ёсны болгох, эмхэлж, төрөлжүүлэхэд ашиглаж байгаа журам, арга хэрэгслийн цогц/

2. Эрх зүйг хэрэглэх техник /эрх зүйг хэрэглэсэн акт буюу тодорхой гэрээ. хэлцэл гэх зэрэг эрх зүйн нэг бүрчилсэн зохицуулалтын актыг бэлтгэх, хэлбзршүүлэхэд хэрэглэгдэж буй журам, арга хэрэгслүүдийн цогц/

3. Эрх зүйг системчилэх техник.

**Эрх зүйн хэм хэмжээний актыг системчлэх техник.**

Эрх зүйн хэм хэмжээний актуудыг эмхлэх, цэгцлэх нь шаардлагатай актыг эрэх, танилцах, хэрэглэх ажлыг хөнгөвчлөх, хэм хэмжээнүүдийн дотоод зөрчил, эрх зүйн хийдлийг арилгах улмаар хууль тогтоомжийг улам боловсронгуй болгох зорилго агуулна. Эрх зүйн хэм хэмжээний актын системчлэх ажиллагааг ихэвчлэн хууль тогтоомжийн системчлэл гэж нэрлэж заншжээ. Хууль тогтоомжийн системчлэл нь эрх зүйн үйл ажиллагааны бие даасан дөрвөн хэлбэрээс бүтнэ:

- Эрх зүйн хэм хэмжээний актын янз бүрийн төрлийн эмхэтгэл, товхимол бэлтгэх, хэвлэх /хууль тогтоомжийн инкорпораци/

- Нэг асуудлыг зохицуулахаар гаргасан олон саланги актуудыг нэгтгэх үндсэн дээр нэг томоохон актыг бэлтгэх, батлах /хууль тогтоомжийн консолидаци/

Зохицуулалтын шаардлага хангаж байгаа хуучин актын хэм хэмжээг хадгалах, мөн шинэ хэм хэмжээг батлах замаа шинэ актуудыг бэлтгэх, батлах /хууль тогтоомжийн кодификаци/

- Төрийн байгууллага, албан газар, фирм, бусад байгууллагуудаас хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрх зүйн хэм хэмжээний актуудыг цуглуулж, тодорхой эмх цэгцтэй байрлуулж, боловсруулалт хийх, хадгалах, мөн зарим сонирхогч этгээд, байгууллага, албан газрын захиалга, эрэлт хүсэлтийн лавлагаа өгөх үйлчилгээ явуулахаар цуглуулах ажиллагаа / хэм хэмжээний актын тоо бүртгэл/[1].

**Хууль тогтоомжийн кодификаци[2]** (codification-эмхлэх цэгцлэх гэсэн латин үг) нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн актуудыг агуулгын хувьд боловсруулах үндсэн дээр байнга тогтвортой үйлчлэх шинжтэй, эмхэтгэн нэгтгэсэн шинэ актыг (кодекс, дүрэм журам гэх зэрэг) **бүтээн төгөлжүүлэх ажиллагаа** юм.

[1] Ч.Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол. УБ.,2010. 236-р тал

[2] Ч.Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол. УБ.,2010. 239-р тал

Кодификаци эрх зүйн хэм хэмжээний актуудын агуулгад нэмэлт өөрчлөлт оруулах. хуучирсан хэм хэмжээ, зарчмыг халах, эрх зүйн хийдлийг арилгах болон шинэ хэм хэмжээг тогтоох ажиллагаа зэрэг явагддаг учраас эрх зүйг бүтээх ажиллагааны нэг төрөл болно.

Хууль тогтоомжийг журамлах, нөхөн сэргээх ажиллагааг нягт хосолдог шинж чанараараа кодификаци нь эрх зүйг бүтээх хамгийн дээд боловсронгуй хэлбэр болно.

МУИС-ийн зөвлөх профессор, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Хууль зүйн ухааны доктор Ш.Цогтоо ‘‘Багш нь 35 дахь жилдээ хууль эргүүлж явна. МУИС-д багшилж судалгаа шинжилгээний ажил хөөснөөс хойшхи 20 гаруй жил нь шинэ Үндсэн хуулийнхаа мөн чанарыг нээн харуурлахад чиглэгдсэн 70 гаруй эрдэм шинжилгээний ажил, түүний дотор их дээд сургуулийн сурах бичиг, нэг сэдэвт бүтээл 11 -ийг тууриваад байна. “Та энэ хугацаанд хамгийн хэцүү. хамгийн чухал ямар ажил хийж бүтээв?” гэж өөрөө өөртөө асуулт тавьж үзэхэд ямар ч эргэлзээгүйгээр “Сүхбаатар аймгийн гүйцэтгэх захиргаанд кодификаторчноор ажиллаж байхдаа улсын архивд идэвхигүй байдлаар хадгалагдаж байсан төр засгийн удирдах дээд байгууллагын 1942-1985 он хүртэлх 43 жилийн эрх зүйн актад системчилсэн кодфикаци хийсэн явдал байлаа’’ гэсэн хариулт гардаг юм. Аливаа байгууллагын өөрчлөлт, шинэчлэл эцсийн дүндээ эрх зүйн шинэчлэл байдаг.[1] гэж дүгнэсэн байна.

Академич, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн С.Нарангэрэл "2010 онд болсон эрдэм шинжилгээний хуралдаанд би оролцож, цагдаагийн байгууллагын эрх зүйн актуудын системчилсэн эмхэтгэлийггаргах үйл ажиллагаа хийгдэх явдал бол цагдаагийн байгууллагаас хууль тогтоомжийг сахин хангах, нийгмийн дэг журмыг хангах, ялангуяа зарим зайлшгүй шаардлагатай үед хүч хэрэглэх үйл ажиллагаанд хууль ёсыг сахиулахад онцгой ач холбогдолтой гэж эрдэмтэн бид үзэж байсан. Энэ үйл ажиллагаа түүнээс хойш хийгдээд, өнгөрч байгаа зургаан жилд цагдаагийн байгууллагын хуульд нийцүүлэн гаргасан эрх зүйн актуудын бүрэн эмхэтгэл системчлэгдэж гарсан байна.

Энэ хугацаанд зөрчилтэй актуудын зөрчлийг арилгах, хууль тогтоомжид нийцүүлэх, төрөлжүүлэн ангилж, системчлэх нөр их хөдөлмөр, үйл ажиллагаа хийгджээ. Энэ нь цаашдаа цагдаагийн байгууллага хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актыг хууль ёсны

[1] Хуулийн хэлтэс сэтгүүл. Ш.Цогтоо, Аливаа байгууллагын өөрчлөлт, шинэчлэл эцсийн дүндээ эрх зүйн шинэтгэл байдаг. 40-41-р тал

үндэслэлтэй болгох, цагдаагийн байгууллагын алба хаагчид тэр дагуу үйл ажиллагаагаа нарийн чанд явуулах, шаардлагатай иргэд, байгууллага, аж ахуйн нэгж тодорхой мэдээлэл авах боломж бүрдсэн, нэг үгээр бол шинжлэх ухааны үндэстэй үйл ажиллагаа хийгдсэн байна.[1] " хэмээн дүгнэсэн байна.

Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлэхдээ хуулийг дээдэлж, хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангаж, цагдаагийн ажил, үйлчилгээг эрх зүйн хүрээнд иргэд олон нийтэд шуурхай, хүртээмжтэй хүргэж, алба хаагчийн хууль ёсны эрх, ашгийг хамгаалах зэрэг нөхцөл, шаардлагуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажилладаг билээ.

Засгын газраас өндөр хөгжилтэй гадаад улс орны стандартыг нутагшуулах тухай бодлого барьж ажиллаж байгаа боловч техникийн стандарт талаас нь хараад нийгмийни харилцааг зохицуулах талаас, мөн төрийн албыг зохицуулах талаас нь олж хараагүй байсан гэж үзэж болно.

Харин хууль сахиулах салбарын хувьд 2009 онд цагдаагийн байгууллага хууль тогтоомжоор хүлээлгэсэн үүргүүдээ хэрхэн хэрэгжүүлэхийг заасан стандартын эхлэлийг тавьж анх удаа "цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам" гэж стандарт журмыг баталсан юм[1] [2]. Дээр өгүүлсэнчлэн нэр томъёоны хувьд үйл ажиллагааны стандарт журам эсвэл стандарт үйл ажиллагааны журам аль нь ч байж болох юм. Жишээ нь төрийн албаны стандарт, бүр үгүй бол аливаа салбарын байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх бодлого үйл ажиллагааны журам гэж нэрлэх боломжтой. Хэдийгээр нэр чухал биш байж болох ч манай нийгмийн харилцаанд үнэт зүйл болсон нэгэн элемент болж ирээдүйд уламжлагдахад бас агуулга зорилго нь өөр өөр ойлгогдохгүй, гажихгүй байх үүднээс анхаарвал зохих зүйл гарцаагүй мөн.[3]

Дэлхийн улс орнуудын цагдаагийн байгууллагууд үйл ажиллагаагаа зохион байгуулах, хяналт тавих, алба хаагч үүргээ гүйцэтгэх явцад эрсдэлтэй тулгарсан үед нөхцөл байдлыг хяналтандаа авч, шийдвэр гаргах зааварчилгаагаар хангах, цагдаагийн алба хаагчийн зайлшгүй хийж

[1] Хуулийн хэлтэс сэтгүүл. 2016 он. С.Нарангэрэл, Цагдаагийн байгууллагын хуульд нийцүүлэн гаргасан эрх зүйн актууд бүрэн системчлэгдсэн, 47 дах тал

[2] Цагдаагийн Ерөнхий газар анх удаа цагдаагийн байгууллага, алба хаагчид хуулиар хүлээлгэсэн 90 гаруй хуулийг хэрхэн хэрэгжүүлэхийг зохицуулсан 9 бүлэг нийт 230 журам баталсан, 2015 оны 11 сарын байдлаар 256 стандарт журам үйлчилж байна.

[3] Ж.Ганбаатар "Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын менежментэд тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам" онол, практикийн хуалд тавьсан илтгэл. 2015

гүйцэтгэвэл зохих буюу хориглосон үйлдэл, оновчтой шийдвэр гаргаж, шуурхай ажиллах чадавхийг бий болгоход онцгой анхаарч байгууллагын дотоод журмыг гаргаж мөрдүүлдэг нийтлэг жишиг бий.

Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, олон улсын эрх зүйн актууд, эрдэмтэн судлаачдын судалгаа, дүгнэлт зөвлөгөө, гадны орны шилдэг туршлага, стандарт. журмуудыг судалсны үндсэн дээр, Засгын газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дах хэсэгт "агентлагын хэмжээнд агентлагын даргын хууль тогтоомжид нийцүүлэн баталсан хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөнө." гэсэн эрх зүйн зохицуулалтын хүрээнд. байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг үр дүнтэй, жигд зохион байгуулах, хяналт тавих арга замыг тодорхойлж, үйл ажиллагааны аргачлал, дэс дараа, горим журмыг тогтоож, системчлэн, кодчилсон “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам” хэмээх эрх зүйн баримт бичгийг эмхэтгэн гаргадаг.[1]

Монгол Улсын Ерөнхий прокурор, Хууль цаазын тэргүүн зөвлөх М.Энх-Амгалан: “Аливаа төрийн байгууллага, алба хаагчдын үйл ажиллагаанд мөрдөгддөг эрх зүйн баримт бичгүүдийн нэг хэсэг нь хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд тухайн байгууллагын удирдлагын шийдвэрээр батлагдсан дотоод журам зааврууд байдаг. Эдгээр заавар, журмууд нь хоорондоо уялдаа холбоотой, хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенцид нийцсэн байхын зэрэгцээ хэрэглэгч нь ашиглахад хялбар, ойлгомжтой байх шаардлагыг хангаж байх нь чухал юм.

Цагдаагийн байгууллага нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хуулийг дээдэлж, хүний эрх, эрх чөлөөг хангах, цагдаагийн ажлыг эрх зүйн хүрээнд ард иргэддээ шуурхай хүртээмжтэй хүргэх, алба хаагчдынхаа эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зэрэг зарчим, шаардлагыг чанд сахин хэрэгжүүлж байх ёстой.

Дээр дурьдсан шаардлага, үйл ажиллагааны онцлог, дэлхийн улс орнуудын цагдаагийн байгууллагын туршлага, жишиг зэргийг харгалзан 2010 онд ЦЕГ-ын дарга, хошууч генерал Д.Сандаг-Очир тушаал гаргаж цагдаагийн байгууллага, алба хаагчын үйл ажиллагааг үр дүнтэй, жигд, шуурхай зохион байгуулах, алба хаагч, ажилтнудыг мэргэжлийн арга зүй, зааварчилгаагаар хангасан, үйл ажиллагаанд нь хяналт тавих арга зам, түүнчлэн цагдаагийн төрөл мэргэжлийн албад, алба хаагч бүрт чиг үүргээ

[1] *Б.Билэгт.* Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. - УБ„ 2013.

хэрэгжүүлэхэд анхаарвал зохих харилцааг оновчтой тодорхойлсон, үйл ажиллагааны аргачлал, дэс дараа, горим журмыг нь тогтоосон "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны багц журам’'-ыг бэлтгэж батлуулах ажлын хэсгийг Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга надаар ахлуулан ажиллуулсан."[1] гэжээ.

Хууль сахиулахын их сургуулийн Сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, Хууль зүйн ухааны доктор, (Ph.d) дэд комиссар Б.Бат-Эрдэнэ: "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны нэгдсэн журмыг боловсруулж мөрдүүлж эхэлсэн нь Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд гарсан ихээхэн дэвшил хэмээн би боддог. Энэ журам цагдаагийн байгууллага, алба хаагчдын үйл ажиллагааг цогц байдлаар, нарийвчилсан зохицуулсан анхны тохиолдол мөн бөгөөд байнга боловсронгуй болгох механизмыг өөртөө агуулж буйн хувьд амьд эрх зүйн акт болж чадсан хэмээн судлаачид үздэг.”[1] [2]

Хууль тогтоомжийн хэрэгжилт төрийн албадлагаар баталгааждаг гэдгийг хэрхэвч мартаж болохгүй. Хууль хэрэгжихгүй байгаагийн гол шалтгаан нь энэхүү ажил учир дутагдалтай байгаатай шууд холбоотой. Засгын газар, түүний бүрэлдэхүүнд багтаж буй албан байгууллага, албан тушаалтнууд хуулийг хэрэгжүүлэхэд хүсэх, шаардах, албадах. бүхий л аргыг хослуулан чадмаг хэрэгжүүлснээр жинхэнэ эрх зүйт төрийн үлгэр загварыг бүрдүүлж чадна. Юуны өмнө төрийн албанд хуулийг дээдлэн биелүүлдэг сахилга, ухамсрыг хэвшүүлэн тогтоох ажлыг цаг алдалгүй үр нөлөөтэй хийх хэрэгтэй.

Хуулийг сурталчлах гэхээсээ илүү батлагдсан хууль, тогтоомжийг шуурхай мэдээлэх, хэрэглэгчидэд нэн даруй хүргэх чиглэлээр холбогдох байгууллагууд ажлын арга барилаа шинэчлэх шаардлагатай. Хууль тогтоомжийн хэрэгжилт, түүний үр нөлөөг судалж, зөрчил, хийдлийг нь арилган уялдаа холбоог нь сайжруулан төгөлдөржүүлэх ажлыг хийх нь нэн чухал. Шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш 25 жилийн хугацаанд түүнд нийцүүлэн 400 орчим бие даасан хуулийг боловсруулан баталсан байна. Эдгээр хуулийг боловсруулан батлах ажлыг амжуулсан нь томоохон ололт амжилт мөн болович ний нуугүй хэлэхэд зарим хуулиудын зүйл, заалтууд

[1] Хуулийн хэлтэс сэтгүүл. Ц.Энх-Амгалан. Хөдөлмөрийн дотоод журам, заавруд нь хоорондоо уялдаа холбоотой, хууль тогтоомжид нийцсэн, хэрэглэгч нь ашиглахад хялбар байх шаардлагг хангаж байх нь чухал.

[2] Б.Бат-Эрдэнэ. Хуулийн хэлтэс, түүний хамт олон цагдаагийн хууль тогтоомжийн “манаач”, “эх баригч” -ийн үүргээ ёсчлон биелүүлж байна. Хуулийн хэлтэс сэтгүүл. 2016., 50 дах тал

хоорондоо зөрчилтэй байдаг, энэ нь хуулиудын хэрэгжилтэнд муугаар нөлөөлдөгийг ч та бид сайн мэднэ. Тийм учраас эдгээр хуулиудын хоорондын зөрчлийг арилгах, кодчилох ажлыг цогцоор нь хийх нь тулгамдсан зорилт болж байна. Энэ талаар сүүлийн жилүүдэд нилээд ярьж байгаа боловч, нүдэнд харагдаж, гарт баригдахуйц ажил хийгдээгүй байна. Энэ чухал ажлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай хамтран Хууль сахиулахын удирдлагын академи, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн хүч бололцоог түшиглэн хийвэл хамгийн зохимжтой гэж үзэж байна.

Зарим хуулиар олгогдсон хэм хэмжээ практикт хэрэгжихгүй байх тохиолдол нилээдгүй байна. Учир нь эдгээрийн биелэлтийг хэрхэн зохион байгуулах талаар гарсан гарсан заавар, журам учир дутагдалтай байна. Тухайлбал,

1. ШШГТХуулийн 137 дугаар зүйлийн 137.10-т: “Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан, албан хаагч тэтгэвэрт гарахаас өмнө 1 жилийн дотор төрийн зардлаар тодорхой сургалтанд хамрагдана.” гэсэн заалт;

2. ШШГТХуулийн 134 дүгээр зүйлийн 134.2.6-д: “хуурамчаар болон санаатай өвчилсөн, эсхүл эрүүл мэнд, бие эрхтэндээ санаатай гэмтэл учруулж эмчлүүлсэн, дур мэдэн ажилд гараагүй, чөлөөнөөс хоцорсон, оргосон хугацааг ял эдэлсэн хугацаанаас хасаж тооцох гэсэн заалт;

Эрх зүйн актыг боловсруулах, бүртгэх, хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийхэд олон жилийн туршид мөрдөгдөж ирсэн зарим дүрэм, журам, заавар шинэ тутам бий болсон эрх зүйн харилцааг зохицуулж чадахгүй болсон, зарим тохиолдолд эрх зүйн акт нь ч олдохгүй болсон, эрх зүйн хийдэл, давхардал, зөрчил ихэссэн зэрэг нэн даруй шийдвэрлэвэл зохих олон асуудалтай тулгарсан байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад мөрдөж буй эрх зүйн актын бүртгэлийг хийснээр нэн даруй хүчингүй болгох, шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах дүрэм, журам, зааврын судалгааг хийхээс ажлаа эхлүүлэх шаардлагатай байна.

ШШГБ мөрдөгдөж байгаа хуулийн заалтыг алба хаагчид хэрхэн хэрэгжүүлэх процедур нь тодорхой бус, эрх зүйн зөрчил агуулсан зэрэг нь хуулийг хэрэгжүүлэх, ёсчлон сахиулах үйл ажиллагаанд ихээхэн бэрхшээл учруулдаг байна.

Эрх зүйн орчны боловсронгуй бус байдал нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, ялангуяа алба

хаагчид хуулийг буруу хэрэглэх, үүний улмаас иргэд хохирох, алба хаагчийн өөрийнх нь эрх ашиг хөндөгдөх явдал олонтоо гарч байв.

Иймд эдгээр эрх зүйн болон бодлогын бичиг баримтын хэрэгжилтийг хангах, ШШГБ-ын эрх зүйн орчинг боловсронгуй болгох үүднээс одоо хүчин төгөлдөр үйлчилж буй дүрэм, журам, зааврын давхардал, хийдлийг арилгах, шинээр дүрэм, журам боловсруулан тэдгээрийг Монгол Улсын хууль, олон улсын стандартад нийцүүлэн системчлэх нь байгууллага, алба хаагчын үйл ажиллагааг улам төгөлдөршүүлнэ гэдэгт итгэл төгс байна.

***Г. Тамир*** *-Хууль сахиулахын удирдлагын академийн*
*Аюулгүй байдлын удирдлага, стратегийн профессорын багийн*
*профессор, хурандаа*

## ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ БА ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ШИНЭЧЛЭЛ

***Товч*** *агуулга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ялангуяа хорих байгууллага нь үндэсний аюулгүй байдлыг хангахад ямар үүрэгтэй оролцдог, эрүүгийн хариуцлагын зорилгыг хангах, хорих ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд тулгамдаж буй гол асуудал нъ юу болох, түүнийг хэрхэн шийдвэрлэх тухай өгүүлсэн.*

***Түлхүүр үг:*** *Аюулгүй байдал, зорилго, зарчим, эрүүгийн хариуцлага, хорих ял, дэглэм, нөхцөл*

Үндсэн хуулийн арван нэгдүгээр зүйлд "Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийтийн дэг журмыг хангах нь хангах нь төрийн үүрэг мөн“ гэж тунхагласан бол Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 4 дүгээр зүйлийн 4.2.1-д “Үндэсний аюулгүй байдлыг хангах үүргийг Монгол Улсын Их Хурал. Монгол Улсын Ерөнхийлөгч. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын Засгийн газар, **хууль сахиулах болон тусгай чиг үүрэгтэй байгууллагууд,** төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагууд гүйцэтгэнэ" гэжээ. Мөн Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-д “Хууль тогтоох, **гүйцэтгэх,** шүүх **эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагууд,** нутгийн өөрөө удирдах байгууллагууд нь үндэсний аюулгүй байдлыг хангах зорилтыг Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн, тус тусын бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үүрэгтэй”, 7 дугаар зүйлийн 7.1-д " .... Зэвсэгт хүчин **бусад** цэрэг’-ийг үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг